



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/415

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.7, 15.9, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль, эрх зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны ээлжит XVIII хуралдааны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуулийн этгээдийн хүсэлт, ажлын хэсгийн дүгнэлтийг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдүүдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Д.Мөнхжаргал), аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10, 2016 оны А/194 дүгээр захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712011253

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖАГСАЛТ

Аймгийн Засаг даргын 2024 оны
8 дугаар сарын 13-ний өдрийн
7/19 дугаар захирамжийн хавсралт

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Хуулийн этгээдийн нэр	Байршил		
1	Айргийн Дэнж ХХК	Хатгал тосгон Жанхайн Тарвалтай хаш "Далайн сувд" хүнсний дэлгүүр	95387766	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
2	Далай ээжийн долгио ХХК	Хатгал тосгон төв "Домогт" хүнсний дэлгүүр	98082768	агууламжтай согтууруулах ундаа худалдах Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
3	Хөвсгөл Баянбуурал ХХК	Хатгал тосгон баруун эрэг "Баянбуурал тур" жуулчны бааз	99389208	агууламжтай согтууруулах ундаа худалдах Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
4	Өндөр бүргийн хишиг ХХК	Чандмань-Өндөр сум 4-р баг 1-р гудамж 161 тоот "Их наяд" хүнсний дэлгүүр	94949900	агууламжтай согтууруулах ундаа худалдах Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
5	Тайгын бүжин ХХК	Цагааннуур сум 1-р баг 4-406 тоот Тайгын бүжин" зоогийн газар, караоке	89825715	агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
6	Ертөнцийн хурд ХХК	Мөрөн сум 7-р баг Хийморь 465-1 байр, зоогийн давхар "Баялаг мөрөн" хүнсний дэлгүүр	89143699	агууламжтай согтууруулах ундаа худалдах Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
7	Эн Эйч Жи ХХК	Мөрөн сум 8-15-25 тоот "Гана" хүнсний дэлгүүр	89993500	агууламжтай согтууруулах ундаа худалдах Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
8	Тосонхүрдэт ХХК	Тосонцэнгэл сум 5-р баг 6-22 тоот "Цэнгэл" хүнсний дэлгүүр	88388844	агууламжтай согтууруулах ундаа худалдах Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах